17. Сорьцын улсын хяналтыг дор дурдсан үй ажиллагаанд хэрэгжүүлнэ:

а/аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмө эрхлэгчдийн үнэт металлаар хийсэн бүтээгдэхүүн сорьц энэ дүрмийн 12 дугаар зүйлд заасан хэмжээ боло түүнд нийцүүлэн гаргасан улсын стандартын шаардлага тохирч байгаа эсэх;

б/үнэт металл, эрдэнийн чулууны бүртгэл тооц зохих хууль тогтоомжийн дагуу хийгдэж байгаа эсэх;

в/үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийс бүтээгдэхүүний бүртгэл, тооцоонд ашиглаж буй жи туухай нь хэмжих хэрэгслийн улсын баталгаажуулалт хамрагдсан эсэх;

г/байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуугаар хийсэн эдлэлийн чанарыг тодорхойлох;
д/улсын эрдэнэсийн сангийн үнэт металлын сорьц, үнийн баталгаажилт.

### Хоёр.Үнэт металлын сорьцын хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

18.Улсын байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:
а/энэ дүрмийн 17 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны чиглэлээр хяналтыг хэрэгжүүлэх;
б/шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, үнэлэлт, дүгнэлт гаргах;
в/улс орны эрх ашгийг эрхэмлэн дээдлэх, хөндлөнгийн нөлөөнд үл автах, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэх.
г/сорьцын улсын хяналтын бүх шатны улсын байцаагч нь хяналт, шалгалтыг хууль, тогтоомжийн хүрээнд явуулж, тавьсан акт, шаардлага, гаргасан дүгнэлтийнхээ үнэн зөвийг бүрэн хариуцна.
19.Улсын байцаагч нь дор дурдсан эрх эдэлнэ:
а/үнэт металл, эрдэнийн чулуу олборлох, боловсруулах, хэрэглэх, хадгалах, борлуулах үйл ажиллагаа эрхлэж буй аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орж хяналт шалгалт хийх, сорьцыг тогтоох, дээж авах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар акт бичих, сорьцын хяналттай холбогдсон асуудлаар байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар, албан шаардлага өгөх, биелэлтийг хангуулах, шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийг гаргуулж авах;
б/сорьцын тэмдгийн дардсанд магадалгаа хийх, сорьц тогтоох шаардлагатай эдлэлийг Үнэт металлын сорьц тогтоох лабораторид шилжүүлэн шалгуулах.

### Гурав.Гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлага

20. Үнэт металлын сорьцын хяналтын улсын байцаагч хууль тогтоомж, журам, дүрэм зөрчсөн, тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд холбогдох хуулийн заалтыг үндэслэн дор дурдсан арга хэмжээ хариуцлага хүлээлгэнэ:

а/улсын байцаагч нь хяналт, шалгалтаас зайлсхийс албан тушаалтныг 5000-20000 төгрөг, шаардлагатай г үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаага хүлээлгэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтныг 300 хүртэл, улсын байцаагчийн албан шаардлагыг эсэргүү сэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлаг биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 500 50000 төгрөг, хянан шалгах үйл ажиллагаанд са учруулсан, гаргах дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхи оролдсон этгээдийг 60000 хүртэл төгрөгөөр тус т торгох;

б/сорьцын ба барааны тэмдгийг хуурамчаар үйлд үнэт металл бус эдлэлийг үнэт металл эдлэл гэж сана тайгаар худалдсан буюу худалдахыг завдаж худалд авагчийг мэхэлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээ гэхээргүй бол хууль бусаар олсон орлогыг хурааж 100 10000 төгрөгөөр тус тус торгох;

в/энэхүү дүрмийн 16-д дурдсан тайланг гаргаж өгө гүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хожи дуулсан, санаатайгаар буруу гаргасан албан тушаалт 10000-50000 хүртэл төгрөгөөр торгох.

## Дөрөв.Бусад зүйл

21.Улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллаг албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлж, хари албан ёсоор өгч байх үүрэгтэй.

2.Сорьцын улсын хяналтын улсын ерөнхий байцаа улсын байцаагчийн тавьсан торгууль, нөхөн төлбөр 15 хоногийн дотор улсын төсвийн орлогод оруулна.

23.Сорьцын улсын хяналтад холбогдох хуу тогтоомжийг зөрчиж хэрэглэгчийн эрх ашгийг хохироо аж ахуйн нэгж, байгууллагын сорьцын хяналтад хамаа үйл ажиллагааг Сорьцын улсын хяналтын албаны ши вэрээр зөрчлийг арилгах хүртэл түр хугацааг зогсоож болно.

24.Сорьцын улсын хяналтын улсын байцаагч тавьсан акт, торгууль, шаардлагыг хүлээн зөвшөөрөө тохиолдолд гомдлоо шийдвэрийг хүлээн авсан өдр хойш 10 хоногийн дотор Сорьцын улсын хяналтын ерөн байцаагчид гаргаж болно. Ерөнхий байцаагч уг гомд хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хя шийдвэрлэнэ. Хэрэв энэ шийдвэрийг эс зөвшөөр гомдлоо шүүхэд гаргаж болно.

25.Сорьцын улсын хяналтын улсын байцаагч үүрэгт
паа зохих ёсоор хийгээгүй, хууль тогтоомж зөрчсөн
л холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түүнд
риуцлага хүлээлгэнэ.

26.Эрдэнэсийн сангийн гүйлгээний сангаас жил бүр
рцуулах үнэт металл, эрдэнийн чулууны хэмжээ болон
борлосон үнэт металл, эрдэнийн чулуунаас эрдэнэсийн
ид зориулан Монгол банкинд худалдан авах доод
мжээг тогтоох саналыг Сорьцын улсын хяналтын алба
лбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж
нгийн хуралд оруулна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 34 Улаанбаатар хот

### Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Газар тариаланг бие даасан салбар болгон
гжүүлсний 40 жилийн ойг 1999 оны 11 дүгээр сарын
-ний өдөр улс даяар тэмдэглэхийг Хөдөө аж ахуй,
лдвэрийн сайд Л.Нямсамбууд зөвшөөрсүгэй.

2.Энэхүү ойг угтах, тэмдэглэн өнгөрүүлэх ажлын
ээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх,
огоон хувьсгал" Засгийн газрын үндэсний хөтөлбөрийн
эгжүүлэлтийг эрчимжүүлэх замаар үр тариа, төмс,
сний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр хангах
га хэмжээ авахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд
Нямсамбуу, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт
алгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХАН

Хөдөө аж ахуй,үйлдвэрийн сайд Л.НЯМСАМБУУ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1998 оны 3 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 36 | Улаанбаатар хот

**Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай**

Казиногийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 д хэсэг, Улсын Их Хурлын 1998 оны 21 дүгээр тогтоолы үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Казиногийн асуудал эрхлэх Зөвлөлийн дүрми 1 дүгээр хавсралтын, Казиногийн асуудал эрхл Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсо тус тус батлсугай.

2.Казиногийн үйл ажиллагаатай холбоотой дүрэ журмыг боловсруулан баталж, казино ажиллуулах онцг эрхийн зөвшөөрөл олгох цалд тендерийн нөхцөл, болзо явуулах журмыг нарийвчлан боловсруулж 1998 о П улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хуу зүйн сайд, Казиногийн асуудал эрхлэх Зөвлөлийн дар Ж.Амарсанаад даалгасугай.

3.Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон зардл жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Сангийн са П.Цагаанд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **М.ЭНХСАЙХАН**

Хууль зүйн сайд **Ж.АМАРСАНАА**

Засгийн газрын 1998 оны 36 д гаар тогтоолын 1 дүгээр хавсра

**КАЗИНОГИЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.Казиногийн асуудал эрхлэх Зөвлөл /цаа "Зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагааг Монгол Улсын Ка ногийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж бо энэхүү дүрмээр зохицуулна.

2.Зөвлөлийн дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн гийн газрын гишүүн байна. Зөвлөлийн дарга Зөвлөйн үйл ажиллагааг удирдаж, түүний үүрэг, зорилтыг эгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газрын өмнө иуцна. Зөвлөлийн даргыг эзгүйд түүний үүргийг ний томилсон Зөвлөлийн гишүүн гүйцэтгэнэ.

3.Зөвлөлийн гишүүнийг Казиногийн тухай хуулийн дугаар зүйлд заасан журам, үндэслэл, хугацаагаар илж, чөлөөлнө.

4.Зөвлөл нарийн бичгийн даргатай байна. Нарийн гийн даргыг Зөвлөлийн дарга томилно.

5.Зөвлөлийн хуралдааныг Зөвлөлийн дарга удирдана.

6.Зөвлөлийн гишүүн нь өөрийн хариуцсан хүрээнд иногийн асуудалтай холбогдсон санал, дүгнэлт, төслийг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

7.Энэ дүрмийн 6-д заасны дагуу Зөвлөлд асуудал улж буй гишүүн саналаа Зөвлөлийн нарийн бичгийн гад холбогдох үндэслэл, судалгаа, тооцооны хамт үлнэ. Нарийн бичгийн дарга асуудлыг Зөвлөлийн гад танилцуулах бөгөөд Зөвлөлийн дарга уг асуудлыг алдаанаар хэлэлцэх хугацаа, дарааллыг тогтооно.

8.Казиногийн үйл ажиллагаатай холбогдсон саналаа иногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа болон аливаа ирхогч этгээд Зөвлөлийн нарийн бичгийн даргад богдох үндэслэл, судалгаа, тооцооны хамт ирүүлнэ. ийн бичгийн дарга саналыг Зөвлөлийн даргад илцуулах бөгөөд Зөвлөлийн дарга шаардлагатай гэж эл уг асуудлыг хуралдаанаар хэлэлцэх хугацаа, аалпыг тогтооно.

9.Зөвлөлийн хуралдааны явцын талаар тэмдэглэл өлнө. Энэхүү тэмдэглэлд Зөвлөлийн дарга, нарийн гийн дарга нар гарын үсэг зурсан байна.

10.Зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол Улсын ль тогтоомжид нийцүүлэн тогтоол, Зөвлөлийн дарга аал гаргаж, биелэлтийг нь хангуулна.

11.Зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн албан гийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

12.Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон зардлыг лөлийн саналыг үндэслэн жил бүрийн улсын төсөвт гана.

13.Зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог нь харгалзан элмэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс тоосон жишгийг баримтлан улирал тутам урамшуулал ж олгоно.

**Хоёр. Зөвлөлийн бүрэн эрх**

14.Зөвлөл Казиногийн тухай хуулийн 8.5-д заасн гадна дараахь эрхтэй байна:

а/казино ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрөл эз шигч казиногийн салбар нээх, тоглоомын төрөл, т нэмэгдүүлэхийг хүссэн өргөдлийг хүлээн авч, кази гийн салбар нээх, тоглоомын төрөл, тоог нэмэгдүү зөвшөөрөл олгох;

б/казиногийн салбар нээх, тоглоомын төрөл, т нэмэгдүүлэх зөвшөөрлийг хүчингүй болгох;

в/өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль тогто жийн дагуу шинжээч, мэргэжлийн хүмүүсийг та оролцуулах, Зөвлөлийн хуралдаанд урьж оролцуулах;

г/казиногийн үйл ажиллагааны зохицуулалтыг болс ронгуй болгох талаар санал боловсруулж холбогдох б гууллагад оруулах;

д/казиногийн асуудлаар төрийн бус байгууллаа гадаадын болон олон улсын байгууллагатай ху тогтоомж, бүрэн эрхийнхээ хүрээнд хамтран ажиллах;

е/хууль тогтоомжид заасан бусад эрх.

15.Зөвлөл Казиногийн тухай хуулийн 8.5-д заасн гадна дараахь үүрэг гүйцэтгэнэ:

1/Казиногийн тухай хуулийн 8.4, 11.1-д заасн гадна дор дурдсан асуудлаар санал, дүгнэлт гарг хуулийн 8.3-т заасан журмын дагуу Засгийн газ оруулах:

а/казино ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрөл хүс өргөдөл, түүнд хавсаргасан бичиг баримт Казиног тухай хуульд заасан шаардлагад нийцэж буй эсэх;

б/онцгой эрхийн зөвшөөрлийн хугацаа сунгаж бо эсэх;

2/казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа эт хууль тогтоомж, тендерийн дагуу хүлээсэн үү биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

3/Засгийн газраас үүрэг болгосны дагуу ка ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрлийг олгох тендерийн нөхцөл, болзлыг боловсруулах, тенде зарлах, дүгнэх;

4/казиногийн үйл ажиллагаатай холбоотой нийт жишиг, зохих зөвлөмж, чиглэл гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;

5/казиногийн байр, тоглоомын хэрэгсэл, холбо тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хууль тогтс стандартад нийцэж байгаа эсэхийг шалгах;

/казино ажиллуулах онцгой эрхийн зөвшөөрөл бүхий эд, түүний салбар, тоглоомын төрөл, тооны бүртгэл ех;
/казиногийн үйл ажиллагааны талаар холбогдох уллагын тайлан,мэдээллийг хэлэлцэж, санал, дүг- гаргах, шаардлагатай асуудлаар зохих шатны уллагад санал оруулах;
/хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Засгийн газрын 1998 оны 36 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## КАЗИНОГИЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

өлийн дарга -Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

үд: -Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Үндэсний татварын ерөнхий газрын дарга;

-Хилийн цэргийг удирдах газрын дарга;

-Нийслэлийн Засаг даргын орлогч;

-Монгол банкны Хяналт шалгалтын газрын захирал /тохиролцсоноор/;

-Гадаад харилцааны яамны Эрх зүйн газрын захирал;

-Улсын аюулгүй байдлыг хангах газрын дэд дарга;

-Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1998 оны 3 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 40 | Улаанбаатар хот |

**Соёл, урлагийн сан
байгуулах тухай**

Монгол Улсын Соёлын тухай хуулийн 21 дүгээ
зүйлийн 5 дахь хэсэг, Түүх, соёлын дурсгалт зүйлий
хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэ
хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газра
ТОГТООХ нь:

1.Соёл, урлагийн сан бий болгож, дүрмийг н
хавсралтын ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Соёл, урла
хөгжүүлэх сан, Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаа
лах сангаас олгосон хугацаа нь хэтэрсэн зээл, түүни
хүүг энэ оны 3 дугаар улиралд багтаан эргэн төлүүлэ
орох орлогыг Соёл, урлагийн санд төвлөрүүлэх ажлы
зохион байгуулахыг Гэгээрлийн сайд Ч.Лхагважав
даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Түүх, соёлы
дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэ
талаар авах зарим арга хэмжээний тухай" Засги
газрын 1994 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 2
дугаар тогтоолын 1 дэх хэсгийн "Түүх, соёлын дурсга
зүйлийг хамгаалах сангийн дүрмийг 6 дугаар хавсра
тын" гэснийг болон "Соёл, урлаг хөгжүүлэх санги
тухай" Засгийн газрын 1995 оны 5 дугаар сарын 20-
өдрийн 74 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсо
тооцсугай.

| | |
|---|---|
| **Монгол Улсын Ерөнхий сайд** | **М.ЭНХСАЙХАН** |
| **Сангийн сайд** | **П.ЦАГААН** |
| **Гэгээрлийн сайд** | **Ч.ЛХАГВАЖАВ** |

Засгийн газрын 1998 оны 40 дүгээр тогтоолын хавсралт

## СОЁЛ, УРЛАГИЙН САНГИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, соёлын ...ай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ...өл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөн...ийн нэмэгдэл эх үүсвэр бүрдүүлэх, түүнийг захиран ...цуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
2. Соёлын тухай хууль, Түүх, соёлын дурсгалт ...лийг хамгаалах, сэргээн засварлах, судлан шинжлэх, ...талчлахад чиглэсэн төсөл, хөтөлбөр шалгаруулж ...хүүжүүлэх, бусад үйлл ажиллагаанд дэмжлэг ...үлэхэд зориулсан хөрөнгийн нэмэгдэл эх үүсвэрийг ...л, урлагийн санд ("сан" гэх) төвлөрүүлэн зар...лна.
3. Соёл, урлагийн сан нь ангийн төлөө бус төрийн ...ийн байгууллага бөгөөд тогтоосон журмаар хийсэн ...дэг, хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай ...на.
4. Сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, ...гийн хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулал... хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Удирдах ...лөл ажиллана.
5. Удирдах зөвлөл нь соёл, урлагийг хөгжүүлэх, ...х, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн ...варлах, сурталчлах төсөл, хөтөлбөрийг сонгон шал...уулах, сангийн ажлын тайланг улирал, хагас жилээр ...элцэж үнэлэлт дүгнэлт өгөх, төлөвлөгөөт хугацааны ...өнгийг бүрдүүлэх, зарцуулах зэрэг асуудлаар шийд... гаргах, гүйцэтгэлд нь хяналт тавих, сангийн ...цэтгэх захирлын хөрөнгө зарцуулах эрх хэмжээг ...тоох эрхтэй.
6. Сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах ...мыг Гэгээрлийн сайд тогтооно.
7. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн төлөөл... гадна урлаг соёлын зүтгэлтэн, мэргэжилтний ...өөллийг оруулна.
8. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй ...глах, захиран зарцуулах асуудлыг хариуцаж өдөр ...мын үйл ажиллагааг удирдах үүрэг бүхий Сангийн ...цэтгэх захирлыг Гэгээрлийн сайд томилно.

9. Салбарын хөгжлийн бодлого чиглэлтэй нийцүү шинэ уран бүтээл туурвих, ном зохиол хэвлэх, тү соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах, с талчлах, соёлын жуулчлалыг хөгжүүлэх, хилийн чан соёлын арга хэмжээ зохион байгуулах төсөл, хөтөлб бусад үйл ажиллагаанд зориулж санг улсын төсв улирлын хувиартайгаар санхүүжүүлж байна.

10. Сангийн хөрөнгийг соёл, урлаг хөгжүүлэх бо түүх, соёлын дурсгалыг хамгаалах гэсэн х чиглэлээр тус тусад нь бүрдүүлэн бүртгэж зориулалт нь зарцуулна. Ийнхүү хоёр чиглэлээр бүрдүүл хөрөнгийн нэгийг нь нөгөөд шилжүүлэн зарцуу асуудлыг Сангийн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

11. Сангийн өөрийн үйл ажиллагааны зардлын төс ажиллагчдын орон тоог Гэгээрлийн сайд, Санг сайдтай тохиролцон тогтооно.

12.Сангийн орлого, зарлагыг соёлын үйл ажиллага төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улир жилийнн тайлан тэнцэлд тусгаж байна.

**Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт**

13. Сангийн хөрөнгө дор дурдсан эх үүсвэр бүрдэнэ:

а)улсын төсвийн хөрөнгө;

б)сангийн хөрөнгөөр зохион байгуулсан урлаг тоглолт, уран бүтээлийн болон түүх, соёлын дурс зүйлийн үзэсгэлэн, сурталчилгаанаас орсон орлс сангийн хөрөнгөөр бий болсон бусад орлого;

в)шинэ уран бүтээл туурвих, улсын болон бүс н гийн чанартай урлаг уран сайхны томоохон арга хэмж түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварла зориулан аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс өг хандив, тусламж;

г)соёл, урлагийг хөгжүүлэх, түүх, соёлын дурсга сэргээн засварлах, хамгаалахад гадаад орон, улсын байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж;

д)түүх, соёлын дурсгалт зүйлийн эх бүтээ Монгол улсын "Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамга тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасан зориу таар ашиглуулсны болон бэлэг дурсгалын зүйл, к дүрс бичлэг болон дуу авианы бичлэг, гэрэл зу марк, ил захидал, цомог, ном зэрэг соёлын ба сурталчилгааны зүйл борлуулсны орлого;

е)соёлын чиглэлтэй жуулчлал, хилийн чанадад зохион байгуулах соёлын арга хэмжээнээс орох орлого;
ж)бусад эх үүсвэр.

14. Сангийн хөрөнгийг удирдах зөвлөлийн шийдвэр үндэслэн дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэх, ажлыг үзүүлэхэд зарцуулна:

а)түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд;
б)урлаг, утга зохиолын шинэ уран бүтээл туурвих, бүтээлийн хуртээл болгох, урлагийн шинэ төрөл чиглэлийг хөгжүүлэх болон онцгой амжилт гаргасан уран бүтээлчдийг дэмжих;
в)түүх, соёлын дурсгалт зүйл, үндэсний соёл, урлагийг гадаадад болон өөрийн оронд сурталчилсан зохиол, дүрс болон дуу авиан бичлэг хийх, ном, илтгэл, танилцуулга, цомог хэвлэх, соёл, урлагийн мэргэжлийн сонин, сэтгүүл гаргахад;
г)үндэсний соёл, урлагийн тоглолт, түүх, соёлын дурсгалт зүйл, уран бүтээлийн үзэсгэлэнг гадаад, дотоодод зохион байгуулахад;
д)олон улсын болон улсын, бүс нутгийн чанартай урлаг, уран сайхан, соёлын арга хэмжээ зохион байгуулахад;
е)түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлахад болон соёл, урлагийн байгууллагад онцгой шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал олж нийлүүлэхэд;
ж)хөгжмийн том хэлбэрийн болон дүрслэх урлагийн бүтээл буттээл улсын санд худалдаж авах, "Түүхийн ...д" кино мэдээ бүтээх;
з)түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлж, үйл ажиллагаа явуулах;
и)археологийн малтлага, судалгаа шинжилгээ хийх эрх мэргэжлийн холбогдох байгууллагад захиалан гүйцэтгүүлэх, олдворыг зохион журмаар бүртгэж музей, үндэсний санд шилжүүлэх;
к)соёлын жуулчлалыг үүсгэн хөгжүүлэх, хилийн чанадад соёлын арга хэмжээ зохион байгуулахад;
л)үндэсний соёлыг хөгжүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг алдаршуулах, шагнан урамшуулах.

15. Сангийн хөрөнгийг энэ дүрэмд заасан арга хэмжээг санхүүжүүлэхээс өөр зүйлд зарцуулахыг хориглоно.

16. Санд төсвөөс олгох хөрөнгийг Гэгээрлийн яам
Сангийн яам тухай бүр хамтран тооцож төвлөрсөн төсө
тусгана.

17. Сангийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлий
дараа онд шилжүүлэн зарцуулна.

**Гурав. Төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулж гүйцэтгэх зарчим**

18. Шилдэг уран бүтээл туурвих, соёл, урлагий
тодорхой төсөл шалгаруулах арга хэмжээг жилд хоё
удаа, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах
сэргээн засварлах, сурталчлахтай холбогдсон төсө
хөтөлбөрийг шалгаруулах арга хэмжээг жилд нэг уда
нийтэд зарлаж хугацаанд нь ирүүлсэн төслүүдий
өрсөлдүүлэх зарчмаар сонгон шалгаруулна. Төсө
хөтөлбөрийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журм
Гэгээрлийн сайд батлан гаргана.

19. Сонгон шалгаруулсан төсөл, хөтөлбөрийг захи
лагч, гүйцэтгэгч болон санхүүжүүлэгч, захиалагчи
хооронд байгуулсан гэрээний дагуу санхүүжүүлж гү
цэтгэнэ.

20. Гэрээнд захиалагчийн шаардлага, гүйцэтгэгчий
үүрэг, хариуцлага, санхүүжүүлэх зарчим, үе ша
хугацаа, үр дүнг тооцох журам зэргийг тодорхой заас
байна.

21. Гэрээний биелэлтийг гэрээ хийсэн этгээдү
хамтран гаргаж нэгдсэн дүгнэлтийг Сангийн удирд
зөвлөл хийнэ. Сан нь жилд 2-оос доошгүй ул
Гэгээрлийн сайдын зөвлөлд ажлаа танилцуулж байна.

**Дөрөв. Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг**

22. Сангийн гүйцэтгэх захирал нь дор дурдс
эрхтэй байна:

а)сангаас санхүүжүүлж байгаа уран бүтээл, ар
хэмжээ. төсөл, хөтөлбөрийн явцыг шалгаж үр дү
тооцох, түүнтэй холбогдсон мэдээ тайлан гаргуу
авах, шаардлагатай гэж үзвэл санхүүжүүлтийг зогсоох

б)сангийн хөрөнгийг энэхүү дүрэмд заасны даг
болон удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээ
захиран зарцуулах;

в)сангийн ажилтнуудыг хөдөлмөрийн хуульд заас
журмын дагуу ажилд авах буюу ажлаас халах, нэмэгд
хөлс олгох, урамшуулах;

г)сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуул-
н, үрэгдүүлж завшигдуулсан, түүнчлэн сангаас урьд
госон зээл, зээлийн хүүг төлөхөөс зайлсхийсэн аж
уйн нэгж, байгууллага, ажилтанд зохих хууль тогтоом-
йн дагуу хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг
лбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, нэхэмжлэл
ргах;

д)сангийн үйл ажиллагааны талаар тушаал, заавар,
рам гаргах, санхүүгийн баримтад нэгдүгээр гарын
эг зурах;

е)удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд
ниг төлөөлөх.

23. Сангийн гүйцэтгэх захирал нь дор дурдсан
лсэн үүрэгтэй:

а)сангийн хөрөнгийг энэ дүрмийн 13 дугаар зүйлд
асны дагуу бүрдүүлэх ажлыг эрхлэх, уг хөрөнгийг
вижуулах, хөрөнгийнн зарцуулалтын үр ашгийг
эшлүүлэх;

б)сангийн санхүүгийн нэгдсэн төлөвлөгөөг боловс-
улан жил бүрийн төвлөрсөн төсөвт тусгуулах;

в)сангийн үйл ажиллагааг сурталчлах, сангийн
рөнгийн улсын төсвийн бус эх үүсвэрийг бүрдүүлэх;

г)сангийн хөрөнгийн зарцуулалтын явц, санхүүжүүл-
н шинэ уран бүтээл, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн
 дүнгийн талаар Сангийн удирдах зөвлөлд улирал
там тайлагнаж байх;

д)сангийн хөрөнгийн орлого, зарлагын тайланг зохих
уль тогтоомж, журмын дагуу холбогдох байгууллагад
гацаанд нь гаргаж өгч байх.

## Тав. Бусад зүйл.

24. Сангийн хөрөнгийг бусдад хандивлах, барьцаа-
х, зориулалт бусаар зарцуулах, зээлээр ашиглах,
иглуулах аливаа үйлдлийг хатуу хориглоно.

25. Энэхүү дүрмийг зөрчсөн албан тушаалтанд хол-
гдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1998 оны 3 дугаар сарын 25-ны өдөр    Дугаар 41    Улаанбаатар хот

**Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөт
бөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засг
газраас ТОГТООХ нь:

1."Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг х
жүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Техник
боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэс
хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл"-ий
дугаар, "Техникийн боловсрол, мэргэжлийн сургал
бодлого зохицуулалтын Үндэсний зөвлөл"-ийн ажил
дүрмийг 3 дугаар, бүрэлдэхүүнийг 4 дүгээр хавсрал
ёсоор тус тус батлсугай.

2.Хөтөлбөр, төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуу
санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр
эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үнд
чиглэл, улсын төсвийн төсөлд тусгах хэрэгжү
байхыг Сангийн сайд П.Цагаан, Гэгээрлийн с
Ч.Лхагважав нарт даалгасугай.

3.Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зох
байгуулж хяналт тавих, биелэлтийг дүгнэж ажилла
Гэгээрлийн сайд Ч.Лхагважав, Эрүүл мэнд, нийгм
хамгааллын сайд Л.Зориг нарт тус тус үү
болгосугай.

4.Энэ хөтөлбөрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүү
дэд хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллахыг аймаг, ни
лэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд    М.ЭНХСАЙХАН

Гэгээрлийн сайд    Ч. ЛХАГВАЖ

Засгийн газрын 1998 оны 41 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

## ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ,МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### НЭГ.Хөтөлбөрийн үндэслэл

ргэжлийн боловсролын талаар олон улсын хөдөлмө-
конвенцид гишүүн орнууд нь үндэсний эдийн засаг,
эм, соёлын хөгжлийн үе шатны онцлог, хөгжлийн
ингийн шаардлагад нийцсэн мэргэжлийн боловсролын
, нээлттэй, шилжилт зохицол сайтай, уян хатан
олцоог бүрдүүлэх замаар хүний нөөцийн болон
лмөр эрхлэлтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэр-
гэж заасан.

хникийн боловсрол, мэргэжлийн сургалт (цаашид
гэх) нь нэг талаас нийгмийн боловсролын үйлчил-
нөгөө талаас нийгмийн материаллаг үйлдвэрлэл
ын нэгдлийг илэрхийлдэг, үр дүн нь ард иргэдийн
эних хэсгийн амьдралын түвшинд шууд нөлөөлдөг,
н засгийн өөрчлөлтөд харьцангуй эртэмтгий
өролын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг юм.

х зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих эхний
хуучин тогтолцооны үед төлөвшсөн аж үйлдвэр,
э аж ахуй, дэд бүтцийн салбарууд задарч, эдийн
ийн хямралд орсон билээ. Дийлэнх үйлдвэрүүд
эгдэхүүнээ дотоод, гадаадын зах зээлд өрсөлдүү-
өөрөө өөрийгөө тэтгэх чадваргүй болсны улмаас
хүн ажлын байргүй болж өнөөдөр Монгол Улсад
гүйдэл, ядуурал бодит зүйл болоод байна.

дөлмөрийн зах зээл дээр ажлын байр хомсдсоноос
-ын хэрэгцээ буурсан төдийгүй, шилжилтийн эхэн
улс орны эдийн засгийн төлөв байдалтай уял-
боловсролын энэ өвөрмөц дэд тогтолцоог өөрчлөх
эл тодорхойгүй байснаас түүний шинэчлэлт харьцан-
удааширч байв.

вч сүүлийн үед үйлдвэрлэлийн салбарууд үнд-
ээ хувьчлагдаж, олон тооны хувийн аж ахуй, жижиг,
үйлдвэр шинээр бий болж эдийн засагт үйлчлэх
йн олон хэлбэр үүсч, үйлдвэрлэл, үйлчилгээ
эгчдэд бие даан амьдарч ажиллах шинэ хандлага бий
өөр байна.

Эдийн засгийн шинэ орчинд өрсөлдөхийн тулд тех технологио шинэчлэх, уламжлалт болон гадны дэвшил технологи эзэмших, зах зээлээ судлах, аж ахуйг хөт шинэ арга барилд суралцах хэрэгцээ шаардлага тэд бий болж байна.

Мөн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн эм хэсгийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилт д шигдэж байна.

Энэ бүгд нь мэргэжлийн боловсролын агуулгад зээл судлал, удирдлагын онолын хэрэглээг тус шаардлагатайг харуулж байгаа төдийгүй мэргэжл боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаагийн илрэл юм.

Түүнээс гадна жил бүр ерөнхий боловсролын сург лийн 8, 10 дугаар анги төгссөн хүүхдийн 30 гаруй х буюу 20 гаруй мянган хүүхэд дараагийн шатны сургуу элсэж чадахгүй, ажлын тодорхой байргүй үлдэж бай юм. Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй 6 мянган ажил эрхлээгүй хүмүүсийн 59 хувь нь мэргэжилгүй байгаа бөгөөд ядуурал, ажилгүйдл байдалд явуулсан улсын үзлэгийн дүнгээс үзэхэд н хүн амын 25,2 хувь амьжиргааны баталгаажих д түвшингээс доогуур орлоготой амьдарч байна. Хөд мөрийн насны, ажил эрхлээгүй ядуу хүмүүсийн 5 хувь нь мэргэжилгүй байна.

Ийнхүү нийгмийн тогтвортой хөгжил, бүс нутг хөгжил, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, хү хөгжлийн нөөцийн талаар төрөөс баримтлах бодл болон өөрчлөлт, шинэчлэлтийн зорилго, зорилтын ү нээс ТБМС-ын асуудалд хандаж, хүн амд үзүүлэх төрлийн боловсролын үйлчилгээний чанар, үр аш дээшлүүлэх зорилт урган гарч байна. Иргэдээс Үнд хуульд заасан "ажил мэргэжлээ чөлөөтэй сонг хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхээ эдл хөдөлмөрлөх үүргээ" биелүүлэхэд нь төрөөс дэмж үзүүлж, тэд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн а амьдралаа дээшлүүлэх арга ухааныг эзэмших та орчин бүрдүүлэх, энэ орчныг бий болгоход хамтын хү чармайлтыг нэгтгэн зохицуулах шаардлага зүй ё тавигдаж байна.

### ХОЁР. Хөтөлбөрийн зорилго

*Эрхэм зорилго*

Иргэд амьдрах чадвараа дээшлүүлэхийн тулд өөр хэрэгцээ, авъяас сонирхолд тохирсон, үр ашг

етэй, бүрэн хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай тех-
йн боловсрол, мэргэжлийн сургалтын мэдлэг,
лага, чадвар эзэмших таатай орчныг бүрдүүлэхэд
үү хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

*Гол зорилго*

нгол Улсын тогтвортой хөгжлийн стратеги, бүс
ийн хөгжил, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах
, хүний хөгжлийн нөөцийн талаар баримтлах бод-
д нийцүүлэн боловсролын тогтолцоог шинэчлэх
лтын хүрээнд техникийн боловсрол, мэргэжлийн
алтын шинэ дэд тогтолцоог бий болгоно.

*Үйл ажиллагааны зорилго*

рөөс хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтэц,
всрол, эрүүл мэнд, экологийн талаар баримтлах
огыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн сонир-
эрэлт хэрэгцээнд тулгуурласан, үйлдвэрлэлийн
длагад нийцсэн техникийн боловсрол, мэргэжлийн
алтын тогтолцоог шинэчлэн энэ төрлийн боловсролын
лгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

## ГУРАВ.Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

йгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд төрөөс баримтлах
ого, чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны бусад
өбөрүүдийг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулан
эний хөтөлбөрийг тодорхой үе шаттайгаар хэрэг-
нэ. Эхний үе нь 1998-2003 он хүртэлх хугацааг
өна.

## ДӨРӨВ.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дэлхийн болон өөрийн
 эдийн засаг, үйлдвэрлэл, техник, технологийн
ийн шаардлага, чиг хандлага, үндэсний онцлогтой
үүлэх;

Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх
р гарсан стратегийн бодлогод нийцүүлэн хууль
н актууд, Засгийн газрын болон олон улсын хөтөл-
үдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуу-

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ монголын төрийн
, төсвийн байгууллагын шинэчлэлийн бодлого, үйл
лагааны шинэ зарчмыг баримтлах;

4.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг иргэдийн боло
ролын түвшин, хэрэгцээ, сонирхолд тулгуурлан зох
байгуулах.

### ТАВ.Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрө
нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:
1.Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв;
2.Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг дэм
сан;
3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;
4.Ядуурлыг бууруулах сан;
5.Сургалтын төрийн сан;
6.Олон улсын зээл, тусламж;
7.Бусад эх үүсвэр.

### ЗУРГАА.Хамтын ажиллагаа

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дотоодын нөөц бололо
ашиглан үр ашигтай ажиллахын зэрэгцээ хоёр та
болон олон улсын мэргэжлийн ба бусад төрөлжсөн б
гууллагатай хамтран ажиллаж, тэднээс ТБМС-д оруу
хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
Төрийн ба төрийн бус байгууллагуудын хамт
ажиллах шинэ арга хэлбэрийг өргөжүүлнэ.

### ДОЛОО.Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дара
зорилтуудыг дэвшүүлж байна:
1.Техникийн боловсрол, мэргэжлийн сургал
удирдлага, зохион байгуулалтын шинэ бүтэц,
ажиллагааны механизмыг бүрдүүлэн хүний нөөі
удирдлагын чадавхийг дээшлүүлэх;
2.Техникийн боловсрол, мэргэжлийн сургаі
хөрөнгө оруулалт хийж, сургалт, дадлагын техі
технологийг шинэчлэн, сургалтын орчинг сайжруу
санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох;
3.Үйлчлүүлэгчдийн сонирхол, эрэлт хэрэгцээ бо
үйлдвэрлэл, техник, технологийн хөгжлийн түвшин
шаардлагад нийцсэн уян хатан сургалтын агу
боловсруулж, түүнийг суралцагчдад шинэ стандаі
шаардлагыг хангахуйц түвшинд эзэмшүүлэх олон ху
барт арга зүйг туршин сургалтад нэвтрүүлэх;

4.Техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмших ргалтын байгууллагын үр ашигтай, оновчтой бүтэц, шинж, байршлыг тогтоож, суралцагчдад үзүүлэх гээрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх;
5.Үндэсний болон олон улсын хамтын ажиллагааны амаар хэрэгжүүлж буй техникийн боловсрол, мэргэжин сургалттай холбоотой хөтөлбөр, төслүүдийг уялан зохицуулж, үр ашгийг нь дээшлүүлэх.

**НАЙМ.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтад удирда, зохион байгуулалтын шинэ бүтэц, үйл ажиллагааны анизмыг бүрдүүлэн хүний нөөцийн удирдлагын чадавг дээшлүүлэх талаар:
1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд стратен удирдлага, төлөвлөлтөөр хангах, ТБМС, хөдөлмөр пэлтийн бодлогыг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт их үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллана. Үндэсний лөлийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын үүн удирдана. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын жээнд зохион байгуулж, арга зүйн удирдлагаар гах үүргийг арга зүй судалгааны алба тус тус лэн гүйцэтгэнэ;
2.Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг атегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, уялдуулан ицуулах, хяналт тавих үүрэгтэй аймаг, нийслэлийн бар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийг тухайн орон гийн Засаг дарга удирдана;
.Аймаг, нийслэлд хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг ион байгуулах, мэргэжлийн болон арга зүйн удирдаар хангах үүргийг аймаг, нийслэлийн нийгмийн логын хэлтэс, Боловсрол, соёлын төв, сургалт, галчилгаа явуулах үүргийг тухайн орон нутаг дахь гэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн галтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл авсан үйлдвэр, ахуйн нэгжүүд тус тус эрхлэн гүйцэтгэнэ. ТБМС-ын зар мэдээлэл сурталчилгаа, сургалт явуулж буй йн бус байгууллага, иргэдийг дэмжинэ;
.Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар гах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж ггээ өгөх үүргийг боловсролын асуудал эрхэлсэн йн захиргааны төв байгууллага болон чиглэлийн ад яамд өөрсдийн харъяа хэрэгжүүлэгч ба тохиагч агентлагуудын оролцоотойгоор гүйцэтгэнэ;

5.Үйл ажиллагааны төвлөрлийг сааруулахын тулд орс
нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллага
сургалтын байгууллагын хүний нөөцийн удирдлагы
чадавхийг дээшлүүлэх замаар ТБМС-ын үйлчилгээнь
чанарыг дээшлүүлнэ;

6.Ардчилал, зах зээлийн нийгэмд зохицсон, ү
ашигтай, уян хатан, мэдрэмтгий ТБМС-ын дэд тогтолцоо
бий болгон төлөвшүүлэх эрх зүйн таатай орчин
бүрдүүлнэ.

Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтад хөрөнг
оруулалт хийж, сургалт, дадлагын техник, технологий
шинэчлэн сургалтын орчинг сайжруулах, санхүүжилтий
механизмыг боловсронгуй болгох талаар:

1.ТБМС-д гадаад, дотоодын хөрөнгө оруулалт хийж
түүнийг МСҮТ-ийн дадлагын газруудын техник, техно
логийг шинэчлэх, шинэ сурах бичиг, сургалтын хэрэг
лэгдэхүүнээр хангах, багшлах боловсон хүчни
чадавхийг дээшлүүлэх, мэдээллийн сүлжээг бий болгох
зарцуулж, сургалтын орчинг иж бүрэн шинэчилнэ;

2.Хөгжлийн шаардлагыг тасралтгүй хангах чадварта
сургалтын орчинг тогтмол дэмжиж байхын тулд үйлдвэр
лэл, үйлчилгээ эрхлэгчид болон байгууллагууд хамтр
ажиллах эдийн засаг, эрх зүйн шинэ механизм
бүрдүүлнэ;

3.ТБМС-ын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болго
төрийн болон төрийн бус байгууллагуудын төрөлжс
сангууд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас мэргэжилт
ажилчин бэлтгэх, ажилчдынхаа мэргэжил дээшлүүлэх
зарцуулах хөрөнгийг харилцан үр ашигтай зарцуулах э
зүйн механизмыг бий болгоно;

4.ТБМС эзэмшихээр элсэгчдийн дийлэнх хэсгийн ний
мийн байдлын өвөрмөц онцлогийг үндэслэн амьжиргаа
баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхэ
нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах иргэдэд сургалт
төлбөрөөс нь гадна суралцах хугацааны амьжиргаа
бусад зардалд нь хөнгөлөлт үзүүлэхэд шаардагд
баталгаатай эх үүсвэрийг олж тогтоон тэдэнд шу
хүргэх арга замыг бий болгоно.

Үйлчлүүлэгчдийн сонирхол, эрэлт хэрэгцээ бол
үйлдвэрлэл, техник, технологийн хөгжлийн шаардлаг
нийцсэн уян хатан сургалтын агуулга боловсруул
суралцагчдад түүнийг шинэ стандартын шаардлаг
хангахуйц түвшинд эзэмшүүлэх олон хувилбарт ар
зүйг туршин сургалтад нэвтрүүлэх талаар:

.Суралцагсдын эрэлт хэрэгцээ болон үйлдвэрлэл, зик, технологийн хөгжлийн тухайн үеийн шаардлагыг гаж чаддаг байхаар мэргэжлийн анхан ба дунд эвсролын мэргэжлийн түвшин болгонд харгалзсан галтын агуулгын уян хатан стандартыг боловсруулж, гэжил бүрээр олон хувилбарт модулын санг дүүлнэ;
.ТБМС-ын стандартын биелэлтийг тогтоох мэргэжлийн эөлөл бүхий хөндлөнгийн хяналтын тогтолцоог аймаг, элэлийн түвшинд бий болгож төлөвшүүлнэ;
.ТБМС эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш ггэх тогтолцоог бий болгож, мэргэжил дээшлүүлэх, эшүүлэх сургалтын агуулга, арга зүйг шинэчлэн шлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлнэ;
.Олон хувилбарт сурах бичиг, гарын авлага бэлт-, сургалт, дадлагын шинэ орчинд нийцсэн арга зүйг эвсруулж сургалтад нэвтрүүлнэ.
ехникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх галтын байгууллагын үр ашигтай, оновчтой бүтэц, шинж, байршлыг тогтоож, тэдгээрийн суралцагчдад үлэх үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх талаар:
.Техникийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн сур-г явуулах сургалтын байгууллагын бүтцэд тушиц гуулийн хэв шинжийг шинээр бий болгон, МСҮТ-ийн эшил, хэв шинжийг оновчтой болгож, үйлдвэрлэл эх сургалтыг дэмжин, эдгээр сургалтын байгууллагад гэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээний анизмыг бий болгоно;
.Бүс нутгийн үйлдвэрлэлийн онцлогтой уялдаж эшсан, одоогоор үйлчилгээний хүрээ нь хязгаар-дмал боловч сургуулийн материаллаг чадавхи нь ецангүй хангалттай байгаа, цаашид газар тариалан-й үйлдвэрлэлийн сэргэлттэй уялдан эрэлт хэрэгцээ эсөн нэмэгдэх хөдөө аж ахуйн чиглэлийн зарим МСҮТ- сургалтын байгууллагын үндсэн чиг үүргийг нь галан хувьчлах ажлыг эхлэнэ;
.Үйлдвэр дээрх сургалт, хөдөлмөрийн захын сур-г, түр сургалт зэрэг албан бус сургалт зохион гуулж буй байгууллага, хүмүүст мэргэжил, арга зүйн клэг үзүүлж, тэдний үйлчилгээний чанар, үйл ажил-ааны хариуцлагыг дээшлүүлэх замаар суралцагсдын ашгийг хамгаалж, мэргэжлийн анхан шатны боловс-ын хүртээмжийг нэмэгдүүлнэ;
.Техникийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн сур-г явуулах үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус

байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийн оролц
хамтын ажиллагааны шинэ арга хэлбэрүүдийг нэвтрүү
тэдний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагын ш
тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлнэ.

Үндэсний болон олон улсын хамтын ажиллагааны шу
маар хэрэгжүүлж буй техникийн боловсрол, мэргэжл
сургалттай холбоотой хөтөлбөр, төслүүдийг уялдуу
зохицуулж, үр ашгийг нь дээшлүүлэх талаар:

1.Энэхүү хөтөлбөрийг хөдөө аж ахуй, аж үйлдв
дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, экологийн чиглэл
Засгийн газар, гадаадын болон олон улсын төрөлж
байгууллагуудаас хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүд
нягт уялдуулан зохицуулж, тэдгээрийг хэрэгжүү
бүтэц, зохион байгуулалт, хүний болон материал
нөөцийг оновчтой хоршин хамтран ажиллах замаар ТН
ын чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

### ЕС.Хөтөлбөрийн хяналт

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, 
нэх ажлыг Үндэсний болон орон нутгийн салбар зөв
гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тал
орон нутгийн салбар зөвлөлүүд Үндэсний зөвлө
Үндэсний зөвлөл нь Засгийн газарт жил бүр
дөрөвдүгээр улиралд багтаан тайлагнаж, нийгэм, эд
засгийн хөгжлийн явцтай уялдуулан нэмэлт тодо
оруулж байна.

### АРАВ. Хөтөлбөрийн шалгуур

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүү
тээр үнэлж дүгнэнэ:

1.Удирдлагын болон сургалтын байгууллагын бүт
оновчтой өөрчлөлт;

2.Санхүүжилтийн хүрэлцээтэй, найдвартай байдал;

3.Сургалт, дадлагын техник, технологийн шинэ
лийн түвшин;

4.Сургалтын агуулга, арга зүйн шинэчлэлийн түвш

5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргын өөрчлөлт;

6.Хүний нөөцийн хангалтын өөрчлөлт, чадав
дээшлэлт;

7.Сургалтын орчны эерэг өөрчлөлт;

8.Эрх зүйн орчны бүрдэлт, нөлөөллийн зэрэг;

9.Эрэлт, хэрэгцээний өсөлт ба нийлүүлэл
харьцаа;

10.Хамтран ажиллах сонирхлын өсөлт;
11.Цаашдын хөгжлийн нөхцөлийг хангах, хөтөлбөрийн
хэм зорилгод нийцсэн байдал.

### АРВАН НЭГ.Хүлээх үр дүн

Боловсролын шинэ тогтолцоонд нийцсэн техникийн ловсрол, мэргэжлийн сургалтын уян хатан, нээлттэй, йдвартай дэд тогтолцооны суурь тавигдаж, сургалтын гтолцоо нь бүхэлдээ шинэчлэгдэн чанартай үйлчилгээ үулах боломжтой болсноор иргэдийн энэ төрлийн ловсролын эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж, үйлч-үлэгчдийн хүрээ өргөжин тэдний амьдралын түвшингээ эшлүүлэх үндсэн нэг нөхцөл бүрдэнэ.

Засгийн газрын 1998 оны 41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

### Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

| д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах болон хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|
| | *I. Удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчин бүрдүүлэх талаар:* | | |
| | ТБМС-ын бодлого зохицуулалтын үндэсний зөвлөл, аймаг, бүсийн зохицуулах зөвлөл, сургуулийн мэргэжлийн төрөлжсөн зөвлөлүүдийг байгуулан ажиллуулах | 1999 | Гэгээрлийн яам |
